



“УС” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ийн 2.3.1. дэх зорилт, “Ус” үндэсний хөтөлбөр, Ховд аймгийн Ногоон хөгжлийн хөтөлбөрийн (2016-2026) хэрэгжилтийг хангах, Усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах, зохистой ашиглах, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Ус” аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулах нэг үндэслэл болж байгаа юм.

Мөн сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт, хүний зохисгүй үйл ажиллагааны нөлөөгөөр усны нөөцийн хомсдол, бохирдол, гамшиг улам эрчимжих хандлагатай болсон. Усны нөөцийг арвижуулах, хамгаалах, зүй зохистой ашиглахад чиглэсэн урт богино хугацааны хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх болсны нэг нь “Ус” аймгийн дэд хөтөлбөр юм.

Уур амьсгалын өөрчлөлт, хуурайшилт, түүнээс үүдсэн цөлжилт идэвхжиж хүрээгээ тэлж байгаа нөхцөлд түүний сөрөг нөлөөг зөөлрүүлэх, байгалийн нөөцийг хадгалах, амьдралын хэв маяг, аж ахуй эрхлэх оновчтой хэлбэрийг тогтоох, эдийн засгийн тогтвортой өсөлт, тухтай амьдралын хэрэгцээг хангах шаардлагатай байна.

Ус ашиглалт, усны хэрэглээнд тавих хяналт боловсронгуй бус, энэ талаарх эрх зүйн орчин, нэгдсэн мэдээлэл, хяналтын тогтолцоо хараахан бүрдээгүй байгаа нь ус ашиглалт, усны хэрэглээний мэдээллийг нарийвчлан гаргаж хянах, менежмент хийхэд хүндрэл учруулж байна.

ХОЁР. ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Ховд аймаг нь 17 сум 91 багтай, 87,3 мянган хүн амтай, 22,6 мянган өрхтэй. 2018 оны усны нэгдсэн тооллогод 222 гол, 890 булаг, 28 рашаан, 116 нуур, 1036 худаг, 4 усан цахилгаан станц, 5 услалтын систем, 3 цэвэрлэх байгууламж тус тус бүртгэгдсэн байна.

Аймгийн нийт ус ашиглалт, усны хэрэглээ жилд 50 орчим сая шоо метр байна. Нийт хүн амын 10.0 хувь нь төвлөрсөн ус түгээгүүрийн сүлжээнээс, 27.0 хувь нь ус түгээх байр, худгаас, 63.0 хувь нь гүний болон гар худаг, булаг, шанд, гол горхиноос

усаа авч хэрэглэж байна. Ус ашиглалтын хэмжээ жилээс жилд өсөн нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд цаашид хот, суурин газрын усан хангамж, ариутгах татуургын хүртээмжийг сайжруулах, мал аж ахуйн болон газар тариалангийн тогтвортой байдлыг хангах, бэлчээр, газар тариалангийн талбайг усжуулах, хөнгөн, хүнс, уул уурхайн болон бусад үйлдвэрлэл болон сэргээгдэх эрчим хүчний салбаруудын хөгжлийг тодорхойлох үндсэн дэд бүтцийн нэг, хөгжлийн голлох хүчин зүйл болж байна.

Аймгийн төлөвлөлтөд тусгагдаагүй газар олголт, хууль бус газар ашиглалтаас үүдэн голын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, хотын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс болон тэжээгдлийн мужийн дэглэм ихээхэн зөрчигдөж байна.

Үйлдвэрлэл, аялал жуулчлал, барилгажилт, уул уурхайн үйл ажиллагааны улмаас голын эх болон эргийн ургамлан нөмрөг, ойн санд ихээхэн хохирол учирч, элэгдэл, эвдрэлд орсоор байна.

Манай аймгийн хэмжээнд голын онцгой болон энгийн хамгаалалтын бүсэд 4339 айл суурьшсан, 1808 иргэн аж ахуйн нэгж 5379 га-д газар тариалан эрхэлдэг, 38 шатахуун түгээх станц, 59 мал угаалгын ванн, 5 ашиглалтын лиценз, хууль бусаар түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох үйл ажиллагааг 12 байршилд явуулж байгаагаас гадна 1000 гаруй худаг уст цэгт эрүүл ахуйн бүс тогтоогоогүйгээс иргэдийн ундны усны эх үүсвэр болон газрын доорх ус бохирдож, аймаг, орон нутгийн ундны усны аюулгүй байдал алдагдаж, хамгаалалтын бүсэд томоохон зөрчлүүд бий болсон байна. Эдгээр зөрчлүүд нь Усны тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм журмуудыг ноцтой зөрчиж байгаагаас гадна тухайн гол нуурууд болон усны сан бүхий газруудынхаа усны нөөцийг хомсдуулах, бохирдуулах, зүй зохисгүй хэрэглээг бий болгох, томоохон голууд дээр ард иргэд үер усны гамшигт өртөж амь нас, эд хөрөнгөөрөө хохирох боломж нөхцөлүүд бүрдсэн байдал нь усны сан бүхий газрын хамгаалалтын бүс тогтоогоогүйгээс үүдэлтэй төдийгүй нэн түрүүнд дараагийн шатны арга хэмжээ авах шаардлагатай байгаа юм.

ГУРАВ. ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ЗОРИЛГО, ЗОРИЛТ

3.1."Ус" аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

3.1.1."Ус" аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, төлөвлөлт, удирдлага, байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг зүй зохистой ашиглахад чиглэсэн бусад хөтөлбөрүүд, эдийн засаг, нийгэм, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлттэй нягт уялдаатай харилцан зохицсон байдлаар хэрэгжүүлэх;

3.1.2."Ус" аймгийн дэд хөтөлбөрийн зорилго, стратегийн зорилт болон үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд иргэн, аж ахуй нэгж, байгууллага, төр, иргэний нийгмийн оролцоог дэмжиж өргөнөөр оролцох, хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

3.1.3.Аймгийн байгаль, цаг уурын онцлог, аж ахуй эрхлэх нөхцөл, хүн амын эрэлт хэрэгцээ, шаардлагыг хангасан байхад чиглэх.

3.1.4 Хөтөлбөрийн зорилго, стратегийн зорилт болон үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоо хамтын ажиллагаа, түншлэлд тулгуурлах;

3.1.5 Бохирдуулагч нь төлөх, ашиглагч нь хамгаалах зарчмыг мөрдлөг болгох;

3.1.6. Хөтөлбөрийн үйл ажиллагаа нь олон нийтэд ил тод, нээлттэй аймгийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн байхын зэрэгцээ хүн амын эрэлт хэрэгцээ, оролцоо, шаардлагыг хангасан байх.

3.2. "Ус" аймгийн дэд хөтөлбөрийн зорилго:

Аймгийн усны нөөцийг хомсдол, бохирдлоос хамгаалах, боломжит нөөцийг зүй зохистой ашиглан аймаг, улс орны хөгжлийн түлхүүр болгох, монгол хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд оршино.

3.3. Хөтөлбөрийн зорилгыг доорх зорилтуудаар дамжуулан хэрэгжүүлнэ:

Зорилт-1: Усны нөөцийг хамгаалах, ашиглалтын менежментийг боловсронгуй болгож ус ашиглалтын олон талт харилцааг зохицуулах.

Зорилт-2: Ус хангамжийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг шинэчлэх.

Зорилт-3: Гадаргын болон газрын доорх усны чанарт хийх шинжилгээ, судалгааны ажлыг эрчимжүүлэх, түүнд тавих хяналтыг өндөржүүлэх.

Зорилт-4: Усны нөөцийн хуримтлалыг бий болгох, хүн амыг эрүүл ахуйн стандартын шаардлагад нийцсэн усаар хангаж, үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн ус хангамжийг сайжруулан тогтвортой хөгжлийг тэтгэх үндсэн нөхцөл бий болгох.

Зорилт-5: Аймгийн усны нөөцийг хомсдол, бохирдлоос хамгаалах, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх.

Зорилт-6: Усыг зүй зохистой ашиглах, дэвшилтэт арга, технологийг уламжлалт зан үйл, ёс суртахууны хэм хэмжээгээр баяжуулан өсвөр, залуу үе, нийт иргэдэд сурталчлах.

ДӨРӨВ. ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Дэд хөтөлбөр нь 2019-2022 онд хэрэгжих ба дэд хөтөлбөрийн зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Зорилт 1-ийн хүрээнд:

4.1.1. Голын урсац бүрэлдэх эхийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах, ой усны сан бүхий газарт хамгаалалтын бүсийг тогтоож, усны нөөцийг хамгаалах.

4.1.2. Булгийн эх, ундарга, орчныг хамгаалж тохижуулах ажлыг тухайн газар оршин суугч иргэд, нөхөрлөлтэй хамтран зохион байгуулах.

4.1.3. Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын, төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн зураглалыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулан, тэмдэг тэмдэглэгээг хийж, бүсийн дэглэмийг мөрдөж ажиллах.

1.4.4. Аж ахуйн нэгж, байгууллага, айл өрхүүдийн усан хангамжинд орчин үеийн шаардлага хангасан тоолуур суурилуулах, “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-ыг мөрдүүлэх.

1.4.5 . Аймгийн төвийн инженерийн хийцтэй худгуудын судалгааг тухай бүр шинэчлэн, цаашид гүний худаг зөвшөөрөлгүй гаргадаг асуудлыг хязгаарлах.

Зорилт 2-ийн хүрээнд

4.2.1. Ховд аймгийн төвлөрсөн усан хангамжийн хайгуул хийж, нөөцийг тогтоох, бохир усыг цэвэрлэх, эргүүлэн ашиглах технологийг судлах.

4.2.2. Усыг олборлох, нөөцлөх, дамжуулах, түгээх тоног төхөөрөмжүүдийн байдалд үнэлгээ өгөх, гидравлик тооцоо хийх, усыг нөөцлөх үүрэг гүйцэтгэж буй том оврын усан сангуудын хүрэлцээ, насжилтын байдалд судалгаа хийх.

4.2.3. Хотын хэмжээнд усыг дамжуулан түгээх үүрэг гүйцэтгэж буй шугам хоолойг үе шаттайгаар шинэчлэх ажлыг үргэлжлүүлэн хийх.

Зорилт 3-ийн хүрээнд

4.3.1. Газрын доорх усны хяналт-шинжилгээний хяналтын цооногуудын мэдээллийг улсын нэгдсэн усны мэдээллийн санд холбох.

4.3.2. Төв цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаанд байгаль орчны аудит хийлгүүлэх, цэвэрлэгээний чанарыг сайжруулах арга хэмжээ авах.

4.3.3. Холбогдох мэргэжлийн байгууллагуудыг усны чанар, найрлага тодорхойлох зөөврийн багаж, хэрэгслээр хангах.

4.3.4. Хүн амын унд ахуйд хэрэглэж байгаа усны чанар, бохирдлын түвшин, хүн амын эрүүл мэнд, өвчлөл хоорондын хамаарлыг тогтоох тандалт судалгаа хийх, мэдээллийн сан үүсгэх.

4.3.5. Айл өрхүүдийн хашаанд гаргасан ундны усны худгуудаас дээж авч шинжилгээнд хамруулж, цаашид авах арга хэмжээний талаар дүгнэлт гаргах.

Зорилт 4-ийн хүрээнд

4.4.1. Хөв цөөрөм байгуулах замаар бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх.

4.4.2. Бэлчээрийн зориулалттай инженерийн хийцтэй худаг, уст цэгийг засварлах, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах.

4.4.3. Хуучин ашиглагдаж байсан услалтын системүүдийг шинэчлэх, услалтын системийн толгойн барилга байгууламжийг шинээр байгуулах сэргээн засварлах арга хэмжээ авч, усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлэх.

4.4.4. Стандартын шаардлага хангахгүй байгаа ундны усны эх үүсвэрийн гүн өрмийн худагт цэвэршүүлэх төхөөрөмжүүдийг суурилуулах.

Зорилт 5-ын хүрээнд

4.5.1. Усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх.
Буянт голын гольдролыг хамгаалах сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх.

4.5.2. Усыг бохирдлоос хамгаалах, бохирдлыг бууруулах усны чанарыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх.

4.5.2. Ус бохирдуулагч эх үүсвэрүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих анхан шатны бүртгэл судалгааг нарийвчлан гаргах.

Зорилт 6-ын хүрээнд

4.6.1. Усыг цэвэр байлгах талаар зөв мэдлэг, хандлага, дадлыг бий болгох сургалт, сурталчилгаа хэлэлцүүлэг зохион байгуулж олон нийтэд мэдээлэх.

4.6.2. Хүн амын дунд усаар дамжин үүсч болох халдварт болон халдварт бус өвчлөлтэй холбоотой асуудлаар хэрэглэгчдэд зориулсан сурталчилгааг хийх.

4.6.3. Сургуулийн өмнөх насны болон ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад усыг зөв зохистой, хэрэглэх дадал заншлыг эзэмшүүлэх, цэвэр усыг уух зориулалтын савтай болгох ажлыг эцэг, эхчүүдийн идэвхтэй дэмжлэгтэйгээр зохион байгуулах.

ТАВ. “УС” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

”Ус” аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн хөгжлийн стратеги хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар бусад талтай хамтран хэрэгжүүлнэ.

Сумын Засаг даргын Тамгын газар, тухайн бүс нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төсөвт, аж ахуйн нэгж байгууллагууд хамтран гүйцэтгэнэ.

ЗУРГАА. ГАРАХ ҮР ДҮН

Хөтөлбөр хэрэгжсэнээр Ховд аймгийн эдийн засаг нийгэм, байгаль орчин, усан хангамж, усны эх үүсвэрийн хамгаалалт, хүний эрүүл мэндэд нааштай сайн үр дүн гарна.

Дараах үр дүнд хүрсэн байна.

6.1. Ховд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын үүрэг хариуцлагыг тодорхой болгож, гүйцэтгэлийн хяналтыг сайжруулснаар голын усны чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг арилгана.

6.2. Ховд аймгийн цэвэрлэх байгууламжуудын цэвэрлэгээний түвшин эрс дээшилсэн байна.

6.3. Арьс, шир, мах, боловсруулах үйлдвэрүүд хаягдал усыг цэвэрлэж, эргүүлэн ашигладаг технологид шилжсэн байна.

6.4. Цэвэрлэх байгууламжаас гарч байгаа усыг хуримтлуулдаг усан сан байгуулах, шар усны үер, хур борооны усыг цуглуулж гадаргын усны хуримтлал үүсгэх, голын усны урсацад тохируулга хийж усны нөөцийн хэмжээг нэмэгдүүлэх замаар газар тариалан, ногоон байгууламжийн усалгаа, үйлдвэрлэлийн хэрэглээнд газар доорх болон цэвэр ус ашиглах явдлыг зогсоох технологийн шийдэл гаргаж, хэрэгжүүлэх ажлыг эхлүүлнэ;

6.5. Гэр хорооллын ус хангамж, ариун цэврийн нөхцөлийг сайжруулснаар гэр хорооллоос Буянт голд үзүүлэх бохирдлын хэмжээг тодорхой хувиар бууруулна.

6.6. Голын ай сав газрын дагуу ашигт малтмалын олборлолтод өртсөн газруудад техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийгдсэн байна.

6.7. Голын урсац бүрэлдэх эх болон түүний цутгал голуудын эхийг тусгай хамгаалалтад авсан байна.

6.8. Аймгийн хэмжээнд томоохон гол нуурын эргийн дагуу тэмдэгжүүлэлт хийж, бүсийн дэглэмийг мөрдүүлсэн байна.

ДОЛОО. “УС” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ.

- “Ус” аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг жилийн эцэст дүгнэж, аймгийн Засаг даргын Зөвлөлд танилцуулах.
- “Ус” аймгийн дэд хөтөлбөрийн биелэлтэд мэргэжлийн байгууллагууд хяналт тавьж ажиллана.

**НАЙМ. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭЛБЭР**

Хөтөлбөрийн санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

- Улсын болон орон нутгийн төсөв;
- Олон улсын байгууллагын хандив, тусламж болон төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;
- Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт;
- Бусад эх үүсвэр.

ЕС. “УС” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт		Төсөв /сая, төгрөг/				Хэрэгжих хугацаа	Санхүүгийн эх үүсвэр	Хэрэгжүүлэх байгууллага
	Өнөөгийн түвшин	Хүрэх үр дүн	2019	2020	2021	2022			
ЗОРИЛТ-1 ХҮРЭЭНД Усны нөөцийг хамгаалах, ашиглалтын менежментийг боловсронгуй болгож ус ашиглалтын олон талт харилцааг зохицуулах									
1.1. Гол, нуур, Булаг шандны эхийг улсын болон орон нутгийн хамгаалалтад авах	Улсын болон орон нутгийн хамгаалалтад ороогүй байгаа.	Улсын болон орон нутгийн хамгаалалтад авагдана.					2019-2022		БОАЖГ, СЗДТГ, ИТХ, СГЗ
1.2. Рашаан, Булгийн эх, ундарга, орчныг хамгаалж тохижуулах ажлыг тухайн газар оршин суугч иргэд, нөхөрлөлтэй хамтран зохион байгуулах.	Рашаан булгийн хамгаалалт хангалтгүй	Рашаан булгийн хамгаалалтайд авна.	5.0	5.0	5.0	6.0	2019-2022	ОНТ, ОУБ	БОАЖГ, СЗДТГ, Нөхөрлөлүүд
1.3. Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын, төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн зураглалыг Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулан, тэмдэг тэмдэглэгээг хийж, бүсийн дэглэмийг мөрдөж ажиллах.	Усан сан бүхий газруудын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийг тогтоогоогүй, тэмдэг, тэмдэглэгээ бүрэн хийгдээгүй.	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хамгаалалтын хилийн цэсийг тогтоолгон, тэмдэг, тэмдэглэгээг хийсэн байх.	10.0	10.0	10.0	10.0	2019-2022	ОНТ, ОУБ, УТ	БОАЖГ, СЗДТГ, СГЗ
1.4 Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагууд, айл өрхүүдэд орчин үеийн шаардлага хангасан тоолуур нэвтрүүлэх, “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-ыг мөрдүүлэх.	Тоолууржуулалт хангалтгүй байгаа	Тоолуур суурилуулснаар усны хэмнэлт ухаалаг хэрэглээ бий болно.	25.0	25.0	25.0	25.0	2019-2022	ОНТ, ХХ	Шим-Ус, ОНӨААТҮГ, МХГ

1.5. Аймгийн төвийн инженерийн хийцтэй худгуудын судалгааг тухай бүр шинэчлэн, цаашид гүний худаг зөвшөөрөлгүй гаргадаг асуудлыг хязгаарлах.	Худгуудын судалгаа хангалтгүй, зөвшөөрөлгүй худаг гаргадаг.	Нэгдсэн тоо, бүртгэлтэй болж, гүний худгийг зөвшөөрөлтэй гаргадаг болсон байна.					2019-2022		БОАЖГ
ЗОРИЛТ-2 ХҮРЭЭНД Ус хангамжийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг шинэчлэх									
2.1. Ховд аймгийн төвлөрсөн усан хангамжийн хайгуул хийж, нөөцийг тогтоох, бохир усыг цэвэрлэх, эргүүлэн ашиглах технологийг судлах.	Хайгуулын ажил хангалттай бус, саарал усны ашиглалт байхгүй.	Усны хайгуулыг хийж, саарал ус ашиглах технологийг судалсан байна.	150.0	200.0	350.0		2020-2021	УТ	АЗДТГ, БОАЖГ, СЗГ, Шим-Ус, ОНӨААТҮГ, МХГ
2.2. Усыг олборлох, нөөцлөх, дамжуулах, түгээх тоног төхөөрөмжүүдийн байдалд үнэлгээ өгөх, гидравлик тооцоо хийх, усыг нөөцлөх үүрэг гүйцэтгэж буй том оврын усан сангуудын хүрэлцээ, насжилтын байдалд судалгаа хийх.	Гидравлик тооцоо байхгүй, насжилтын судалгаа байхгүй.	Судалгаа, тооцооллыг үндэслэн цаашид хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх.		5.0	5.0		2020-2021	ОНТ	Шим-Ус, ОНӨААТҮГ, МХГ
2.3. Хотын хэмжээнд усыг дамжуулан түгээх үүрэг гүйцэтгэж буй шугам хоолойг үе шаттайгаар шинэчлэх ажлыг үргэлжлүүлэн хийх.	Ус дамжуулах шугам хуучирсан.	Ус дамжуулах шугамуудыг үе шаттайгаар шинэчилсэн байна.		350.0		350.0	2020-2022	ОНТ	ГХБХБГ, Шим-Ус ОНӨААТҮГ
ЗОРИЛТ-3 ХҮРЭЭНД Гадаргын болон газрын доорх усанд шинжилгээ хийх, үнэлгээ, судалгаа явуулах									
3.1. Газрын доорх усны хяналт шинжилгээний хяналтын цооногуудын мэдээллийг улсын нэгдсэн усны мэдээллийн санд холбох.	Жил бүр хийдэггүй	Шинээр цахим сантай болно.					2019-2022		БОАЖГ, ХНХГСЗ
3.2. Төв цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаанд байгаль орчны аудит хийлгүүлэх, цэвэрлэгээний чанарыг сайжруулах талаар арга хэмжээ авах.	Аудит хийгдээгүй.	Байгаль орчны аудит хийлгүүлж, цэвэрлэгээний чанарыг сайжруулсан байна.		15.0		15.0	2020-2021	ОНТ	БОАЖГ, Шим-Ус ОНӨААТҮГ, МХГ
3.3. Холбогдох мэргэжлийн байгууллагуудыг усны чанар,	Багаж байхгүй.	Усны чанар, найрлага		25.0		25.0	2020-2022	ОНТ	БОАЖГ, СЗГ, МХГ

найрлага тодорхойлох зөврийн багаж, хэрэгслээр хангах.		тодорхойлох зөврийн багаж, хэрэгсэлтэй болсон байх.							
3.4. Хүн амын унд ахуйд хэрэглэж байгаа усны чанар, бохирдлын түвшин, хүн амын эрүүл мэнд, өвчлөл хоорондын хамаарлыг тогтоох тандалт судалгаа хийх, мэдээллийн сан үүсгэх.	Усны чанар, бохирдол хүн амын эрүүл мэндийн өвчлөлд нөлөөлж буй талаарх судалгаа хангалтгүй.	Судалгааны ажил хийгдсэн байх.	5.0			5.0	2019-2022	ОНТ	ЭМГ, МХГ
3.5. Айл өрхүүдийн хашаанд гаргасан ундны усны худгуудаас дээж авч шинжилгээнд хамруулж, цаашид авах арга хэмжээний талаар дүгнэлт гаргах.	Айлууд хашаандаа гар худаг гарган унд ахуйдаа ашиглаж байгаа.	Хашаандаа унд ахуйн зориулалтаар ашиглаж буй худгуудад шинжилгээ хийсэн байна.					2019-2022		ЭМГ, МХГ
ЗОРИЛТ-4 ХҮРЭЭНД Усны нөөцийн хуримтлалыг бий болгох, хүн амыг эрүүл ахуйн стандартын шаардлагад нийцсэн усаар хангаж, үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн ус хангамжийг сайжруулан тогтвортой хөгжлийн тэтгэх үндсэн нөхцөл бий болгох;									
4.1 Хөв цөөрөм байгуулах, Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах.	Хөв цөөрөм байгуулагдахгүй байгаа.	Бэлчээрийн усан хангамж сайжирна.	80.0	80.0	80.0	80.0	2019-2022	ОНТ	ХХААГ, БОАЖГ
4.2 Бэлчээрийн зориулалттай инженерийн хийцтэй худаг гаргах, уст цэгийг засварлах, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах.	Бэлчээрийн усан хангамж дутмаг	Уст цэгүүд хэвийн үйл ажиллагаатай болж, хүртээмж нэмэгдэнэ.	100.0	100.0	100.0	80.0	2019-2022	ОНТ, УТ	ХХААГ, БОАЖГ
4.3 Хуучин ашиглагдаж байсан услалтын системүүдийг шинэчлэх, сэргээн засварлах, услалтын системийн толгойн барилга байгууламжийг шинээр байгуулах арга хэмжээ авах	Засвар үйлчилгээ хийгдэхгүй байгаа	Услалтын системүүдийн үр ашиг гарна.	100.0	100.0	100.0	100.0	2019-2022	УТ	ХХААГ, БОАЖГ
4.4. Стандартын шаардлага хангахгүй байгаа ундны усны эх үүсвэрийн гүн өрмийн худагт цэвэршүүлэх төхөөрөмжүүдийг суурилуулах.	Зарим сумдад ус цэвэршүүлэх төхөөрөмж суулгах ажил хийгдэж байгаа.	Унд, ахуйн шаардлага хангасан усаар хангагдах.	170.0				2019-2022	УТ	ГХБХБГ, БОАЖГ
ЗОРИЛТ-5 ХҮРЭЭНД Аймгийн усны нөөцийг хомсдол, бохирдлоос хамгаалах, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх.									

5.1. Усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх.	Төлөвлөгөө байхгүй.	Аймгийн хэмжээнд төлөвлөгөө хэрэгжинэ.	5.0			5.0	2019-2022	ОНТ	БОАЖГ, СГЗ, МХГ, УЦУОШТ, Шим-УС ОНӨААТҮГ,
5.2. Буянт голын гольдролыг хамгаалах, сэргээх ажлыг хийж хэрэгжүүлэх	Гольдролыг хамгаалах ажил хийгдэхгүй байгаа.	Гольдрил хамгаалагдаж сэргээгдэнэ.	15.0			15.0	2019-2022	ОНТ, ОУБ	БОАЖГ, СГЗ, УЦУОШТ,
5.3. Ус бохирдуулагч эх үүсвэрүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих анхан шатны бүртгэл судалгааг нарийвчлан гаргах.	Хяналт байхгүй.	Бүртгэл судалгаатай болж хяналт сайжирна.					2019-2022		БОАЖГ, СГЗ, МХГ, УЦУОШТ,
ЗОРИЛТ-6 ХҮРЭЭНД Усыг зүй зохистой ашиглах, дэвшилтэт арга, технологийг уламжлалт зан үйл, ёс суртахууны хэм хэмжээгээр баяжуулан өсвөр, залуу үе, нийт иргэдэд сурталчлах.									
6.1. Усыг цэвэр байлгах талаар зөв мэдлэг, хандлага, дадлыг бий болгох сургалт, сурталчилгаа хэлэлцүүлэг зохион байгуулж олон нийтэд мэдээлэх.	Зохион байгуулдаг.	Цэцэрлэг, сургууль ард иргэдийг олноор хамруулах	2.0	2.0	2.0	1.0	2019-2022	ОНТ	БОАЖГ, СГЗ, БСУГ
6.2 Хүн амын дунд усаар дамжин уусаж болох халдварт болон халдварт бус өвчлөлтэй холбоотой асуудлаар хэрэглэгчдэд зориулсан сурталчилгааг хийх	Сургалт, сурталчилгаа хангалтгүй байна.	Сургалт, сурталчилгааг системтэй болгоно.	2.0	2.0	2.0	1.0	2019-2022	ОНТ	БОАЖГ, СГЗ, МХГ, БСУГ
6.3 Сургуулийн өмнөх насны болон ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад усыг зөв зохистой, хэрэглэх дадал заншлыг эзэмшүүлэх, цэвэр усыг уух зориулалтын савтай болгох ажлыг эцэг эхчүүдийн идэвхтэй дэмжлэгтэйгээр зохион байгуулах,	Уг ажил тодорхой төлөвлөгөөтэй хийгдэхгүй байна.	Төлөвлөгөөтэйгөө өр хийж гүйцэтгэнэ.	2.0	2.0	2.0	1.0	2019-2022	ОНТ	БОАЖГ, СГЗ, БСУГ
ДҮН			2019	2020	2021	2022			
			671,0	921,0	681,0	719,0			
НИЙТ			2,992						

.....оОо.....